

МОНГОЛ, ТҮРЭГ УГСААТНЫ “ШУВУУ” ШҮТЛЭГ

Б.АЗЗАЯА

*МУИС-ийн Гадаад хэл соёлын сургууль, Түрэг судлалын төв,
e-mail: centreturkicamongol@yahoo.com*

Түлхүүр үг: “Шувуу” шүтлэг, Монгол, Түрэг угсаатан, сурвалжийн мэдээ

Өгүүллийн товч агуулга: Бид уг өгүүлэлдээ хэд хэдэн сурвалжийн мэдээ болон археологи, угсаатны зүйн эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан Монгол, Түрэг угсаатны шувуу шүтлэгийн талаар авч үзсэн болно.

Нүүдэлчин овог аймгууд суурин соёл иргэншилт ард түмнийг бодвол байгаль дэлхий, ан амьтадтайгаа илүү ойр байдаг нь тэдний өдөр тутмын амьдрал, ёс уламжлалд тусгалаа олсон байдаг билээ. Үүний нэг тод жишээ нь шувуутай холбогдох зан үйл юм.

Төв Азийн нүүдэлчид шувууг тэнгэрийн амьтан хэмээн тотемчлон шүтдэг байснаа хожим ан гөрөөнд сурган амьдрал ахуйдаа ашиглах болжээ.

Жигүүртэнг бэлгэшээж, тэр дундаас харцага, шонхор, бүргэд, шаазгай зэргийг онцлон овог аймгийн шүтээн болгох явдал эртний нүүдэлчин аймгуудын дунд элбэг байсан нь түүхэн сурвалж болон угсаатны зүйн эх хэрэглэгдэхүүнээс тодорхой ажиглагддаг.

Тэд махчин шувуудын овогт багтах харцага, шонхор, бүргэд зэрэг хурдан шаламгай, хурц хараатай, асар өндрөөс идэш болох амьтнаа олж харан барьдаг шувуудыг тэжээн дасгаж, ан гөрөө авлахад сургадаг байжээ. Тэдгээр шувуудын байгалиас заяасан онцгой шинж, хүч чадалд нь тохируулан:

Бүргэдээр: үнэг, чоно, хярс, туулай зэрэг хөхтөн амьтдыг

Харцага, шонхороор: галуу, хур, сойр, нугас зэрэг жигүүртэн шувуудыг бариулан ахуй амьдралдаа хэрэглэдэг байжээ. Эдгээр шувууд хурдан шаламгай, эрэмгий дайрч ангаа барьдаг учраас тэдгээрийг хурд хүч, эр зоригийн бэлгэдэл ч болгож байсан байна.

“Эдүгээ махчин шувуудыг тэжээж, ан хийх уламжлал халх монголчуудын дунд мартагдан орхигдож, зөвхөн түрэг хэлт ястны дунд бүргэдээр ан хийх хэлбэрээр хадгалагдан үлдсэн хэдий ч монголчуудын хуучин түүх судар, дүрслэх урлагийн бүтээл, хэлний шинжлэлийн дурсгал тэргүүтнийг байцаан үзэхэд, тэдний ан агнуурт “шувуулахуй” нь нэг чухал төрөл зүйл байсан төдийгүй Монголчууд энэ талаар нэлээд цэгцэрч боловсорсон мэдлэг бүхий ард түмэн байсан нь эш баримттай ажгуу” (Эрдэнэбат, 2003:157). Тухайлбал, Монголын Нууц товчооны 27-р зүйлд: “qarcıqai-ba’an teyile’üljü o’orba noqot qalawut qoji’ulas tutum qongsi’ut hünji’üles tutum hüngsi’üt hünistele talbiba” хэмээн гардаг (Rachewiltz, 1972:17). Түүнчлэн араб үсэг, татар хэлээр бичигдсэн “Däftär-i Ćingiz-nāmā” сурвалжийн 27 дугаар талд Чингис хаан ноёддоо нэрлэж өгсөн шувуудаараа ан хийлгэж, авласан шувуудыг нь авчруулан шагнаж байгаа мэдээ буй (Аззаяа, 2006: 72-73).



Зураг 1. Алтан титэм



Зураг 2. Тахилын хавтан



Зураг 3. Мэлхий толгойн мэлхий чулуу



Зураг 4. Көличурын тахилын хавтан

Ийнхүү олон зүйл сурвалжид эрт үеэс шувуугаар ан хийлгэдэг байсан нь тэмдэглэгдэн үлдсэнээс гадна шүтэн дээдэлдэг байсан талаар ч мөн дурдагдсан байна. Монголын Нууц товчооны 63-р зүйлд: “*yisügei quda bi ene söni jewüdün jewüdleba bi saqān singqor naran sara qoyar-i atqun nisju irejü qar de’ere minu*

tu'uba.....ya'un jewüdün aqu ta kiyat irgen-ü sülder irejü..." (Rachewiltz, 1972: 25) гэж буй. Ихэнх эрдэмтэд үүнийг Хиад Боржигон овгийн сүлд гэдэг дээр санал нэгтэй байдаг. Мөн өмнө дурдсан "Däftär-i Ćingiz-nāmā" сурвалжийн 23-25 дугаар талд Чингис хаан ноёддоо шүтээн шувуу нэрлэн соёрхож байгаа тухай тодорхой дурдагдана (Азаяа, 200:70-71). Ийнхүү Чингис хаан шүтээн шувуу соёрхсон талаар хэд хэдэн сурвалжид ч (Шакарим Кудайберды-улы, 1990; Пэрлээ, 1975) тохиолдож байгаа талаар судлаач доктор Ц.Төрбат тэмдэглэсэн байна (Төрбат, 2006: 293-296).

Ер нь нүүдэлчин овог аймгууд ямар нэгэн амьтныг шүтэх нь түгээмэл байсан бөгөөд үүнтэй холбоотойгоор дээд тэнгэрийн зууч гэгдэх бөө, удгад могой, шувуу гэх мэт шүтдэг амьтныхаа дүрээр хувцас чимэглэлээ засдаг байна. Жишээлбэл "бүргэд болоод бусад махчин шувуудыг бөө удгадыг тэнгэртэй холбодог элч гэж үздэг учраас малгай, дээл, гутал гээд бүх хувцсаа шувууны өдөөр чимэглэдэг ажээ. Ийм хэлбэрийн чимэглэл ихэвчлэн Алтай, Саяны нурууны хэсэгт тархжээ" (Bahaeddin Ögel, 1998: 38).

Зөвхөн түрэг, монгол угсаат бөө нар хувцас хунараа шувууны өдөөр чимэглэдэг бус Индианы зарим овгийн бөө нар мөн өд сөдийг эрхэмлэн зүүдэг нь нэг талаараа "нас барсан хүний сүнс шувуу болон нисэн оддог", нөгөө талаараа "шувуу болон нисэн одсон сүнстэй харилцах" гэсэн ойлголттой холбоотой байж болох юм. Түрэг угсаатнууд бүргэд, шонхрыг бусад шувуудаас илүүтэйгээр хүндэтгэдэг бөгөөд үүнийг тухайн шувууд амьдрал ахуйд нь чухал байр суурь эзэлдгээр тайлбарлаж болох юм. Үүнтэй холбогдон Якутын өвөг *бүргэд*, Тэлэүт, Мэргэдийн өвөг *хар бүргэд* байсан гэх домгууд эдүгээ хүртэл тэдний дунд яригдсаар байдаг ажээ.

Түүнчлэн бөө, удирдагч болон баатрууд бүргэд мэтийн шувуудаас үүссэн гэх домог элбэг байдаг. Жишээ нь: Туркийн эрдэмтэн Яшар Чорухлу өөрийн бүтээлдээ "Буриадын нэгэн домогт "тэнгэрийн элч болон хүний ертөнцөд ирсэн бүргэд, хүмүүстэй хэл ойлголцохгүй байсан тул тэнгэрээс хүний хэл сургахыг эсвэл өөрийн хүүг илгээхийг хүсэхэд, тэнгэр түүний хоёрдугаар хүслийг биелүүлж, улмаар бүргэд нэгэн модны доор нойрсож асан эмэгтэйтэй нийлж анхны бөөг төрүүлсэн" гэж өгүүлснийг тэмдэглэжээ (Yaşar Çoruhlu, 1995:75-76).

Монгол Туркийн хамтарсан "Орхоны хөндий дэх Түрэгийн үеийн зарим хөшөө дурсгалыг хадгалах, хамгаалах, сэргээн засварлах" төслийн хүрээнд Архангай аймгийн Хашаат сумын нутаг, Хөшөөт цайдам хэмээх газарт орших эртний Түрэгийн хаан Билгэ-д зориулсан цогцолбор дурсгалд хийсэн 2001 оны малтлага судалгаагаар алтан титмийн дуураймлыг илрүүлсэн билээ (Moğolistan'daki Türk Anıtları Projesi 2000 Yılı Çalışmaları, 2002: 42; Sertkaya, Alyılmaz, Battulga, 2001) (Зураг 1). Энэхүү титэмнээ эрдэнийн чулуу (жимсийг төлөөлүүлсэн бололтой) зуусан шувууг дүрсэлсэн нь сонирхол татаж байгаа юм.

Эдгээрээс үзвэл Монгол, Түрэг угсаатнууд хоёул, шувууг эрхэмлэн дээдэлж иржээ. Энэхүү уламжлалын талаар өгүүлэх ахул модны талаар дурдахгүй өнгөрч эс болох бизээ. Учир нь Монголчуудын өвөг дээдэс ой модыг эх этүгэн, шувууг эцэг хэмээн ойлгодог байжээ. Тухайлбал Халимагууд өөрсдийгөө "Уд модон эхтэй, ууль шувуун эцэгтэй" хэмээн хэлэлцэнэ (Byeebid, 1990: 4 / Buyanbatu, 1990: 4). Харин Түрэг угсаатнууд модыг амьдралын мод, тэнгэр бурхнаа золгох гүүр шат хэмээн ойлгож, шувууг бурханы элч, насан эцэслэж буй хүний сүнснийг тэнгэрт хүргэн шинээр мэндлэн буй хүүхдэд бурханаас сүнс залж ирдэг хэмээн итгэцгээдэг. Түүнчлэн Түрэг угсаатнуудын нэгэн тотем болох "ариун мод"-ны нэг мөчир дээр

бүргэд, бусад мөчир дээр нь өөр шувууд суух бөгөөд бүргэд бол бөө удганы сүнс, бусад нь энгийн хүмүүсийн сүнс гэж үзэх нь ч байдаг (Yaşar Çoruhlu, 1995: 74).

Энэ мэтчилэн шувууг тотемчлон шүтдэг байсан учраас эртний Түрэгүүдийн оршуулгын зан үйлд холбогдох хамгийн нийтлэг зүйл болох тахилын хавтан дээр хүртэл шувууны дүрс сийлсэн тохиолдоно. Тухайлбал, Келтигиний гэрэлт хөшөөний ойролцоох нэгэн байгууламжаас жимс зуусан хоёр шувуу бүхий тахилын хавтан гарсан байна (Зураг 2). Үүнтэй төстэй нэгэн зүйл бол Өвөрхангай аймгийн Хархорин сумын Мэлхий толгой хэмээх газар буй мэлхий чулууны хоёр гуян дээр шувуу сийлсэн байдаг (Зураг 3). Мөн Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Хөшөөн тал хэмээх газар байх Көличурт зориулсан гэрэлт хөшөө, цогцолборын тахилын хавтанд шувууны дүрс буй (Зураг 4). Дээр дурдсан, жимс зуусан хоёр шувууг чихтэйгээр дүрсэлсэн нь домгийн хүчирхэг амьтан, тэнгэрийн шувуу болохыг илтгэсэн бололтой. Энэ нь хаад ихэс, язгууртныхаа сүнсийг дээд тэнгэрийн буюу домгийн шувуу болон нисэн оддог гэж үздэг байсантай холбоотой байж болох юм.

Монголын руни бичгийн сонгодог дурсгалууд, тухайлбал, Келтигин, Билгэ хаан [зүүн талын 4-р мөр]-ы гэрэлт хөшөөний бичээст “ilig tutup törüg itmiş. Ōzi anča kergek bolmiş (улсыг байгуулж, төрийг үүсгэв. Өөрөө тийн нисэн одов)” гэх мэтчилэн өгүүлсэн нь эртний түрэгүүд сүнс шувуу болон нисэн оддог гэдэгт итгэдэг байсныг давхар гэрчилж байна.

НОМЗҮЙ

- Азаяа Б, 2006. “Dāftār-i Čingiz-nāmā” сурвалжийн судалгаа, Corpus Scriptorum, Tom. V, УБ.
- Идэрхангай Т., 2004. Эртний түрэгийн үеийн тахилын хавтан дээрхи шувууны дүрслэл,.. МУИС, ГХСС, Түрэг судлалын тэнхимийн гар бичмэлийн сан хөмрөг УБ
- Пэрлээ Х. 1975. Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь, УБ.
- Төрбат Ц., 2006. Эртний монгол овгийн бэлгэдлүүд, Acta Mongolica, Vol.VI(267), УБ.
- Шакарим Кудайберды-улы, 1990. Родословная тюрков, киргизов, казахов и ханских династий, перевод. Б.Каирбекова, Алма-Ата.
- Эрдэнэбат У., 2003. Монголчуудын “шувуулахуй” агнуурын уламжлалын асуудалд. Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг, XIX боть(193), УБ.
- ᠬᠡ, Выебл᠘᠐, Moehgolcooa oa Modoa O Sidolhit, FoiB* Moehgo& oa Soyol& oa kibe& oa HoRll t, 1990, Df& t 4 /Ke. Buyanbatu, Mongyolčud-un modun-u sitülge, Öbür Mongyol-un soyul-un keblel-ün qoriy-a, 1990, tal-a 4/
- Bahaeddin Ögel, 1998. Türk Mitolojisi, c.I, Ankara
- Moğolistan’daki Türk Anıtları Projesi 2000 Yılı Çalışmaları, -TC. Başbakanlık, Türk İşbirliği ve Kalkınma İdaresi Başkanlığı, Ankara, 2002, s.42. Fot ve çizim. 11-14.
- Rachewiltz I. de, 1972. Index to the Secret History of the Mongols, Bloomington
- Sertkaya O.F. Alyılmaz C., Battulga Ts., 2001. Album of the Turkish monuments in Mongolia, Ankara
- Yaşar Çoruhlu, 1995. Türk Sanatında Hayvan Sembolizmi, İstanbul

РЕЗЮМЕ

Б.Азаяа

НЕКОТОРЫЕ ЗАМЕЧАНИЯ К ПРЕДСТАВЛЕНИЮ О ПТИЦЕ У ДРЕВНИХ ТЮРКОВ И МОНГОЛОВ

На основе ряда свидетельств, в частности археологических и фольклорных материалов, автором статьи предпринята попытка, осмыслить культ птицы, в частности, таких как беркут, сокол и подобных хищных в мифологическом представлении древних Тюрков и Монголов.